

## МОНГОЛЫН УЛАМЖЛАЛТ ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ӨӨРЧЛӨЛТ, ШИНЭЧЛЭЛ

М.Баттөмөр

Монгол Улсын Их Сургууль, Түүхийн судалгааны хүрээлэн.

**Өгүүлийн тоеч утга:** 1921 оны хувьсгалын дараа байгуулагдсан уламжлалт төрийн бус байгууллагууд, ялангуяа МХЗЭ, МҮЭ-ийн үйл ажиллагааны өөрчлөлт, шинэчлэлийг гарган тавьж, эдүгээгийн уламжлалт төрийн бус байгууллагын үйл ажиллагааны нийтлэг ба онцлогийн тухай өгүүлсэн болно.

**Түлхүүр үг.** Сонирхлын бүлэг, төрийн бус байгууллага, олон нийтийн байгууллага, Монголын хувьсгалт залуучуудын эвлэл, Монголын Үйлдвэрчний эвлэл, эмэгтэйчүүдийн байгууллага, өөрчлөлт шинэчлэл.

Монгол оронд төрийн бус байгууллагууд бий болсон нь ХХ зууны эхэн үеийн улс төрийн түүхэнд гарсан цоо шинэ үзэгдэл байв. Хоршоо, эвлэлийг төрийн бус байгууллагад оруулдаг ангиллаар авч үзвэл бүр Олноо өргөгдсөн Монгол улсын үед худалдааны хоршоо эх үүсвэрээ тавьсан нь сонирхлын бүлэг бий болж, улмаар төрийн бус байгууллага үйл ажиллагаагаа эхэлсэн гэж үзэж болохоор байна.

1921 оны үндэсний ардчилсан хувьсгал ялсны дараахан VIII сарын 25-нд Монголын Хувьсгалт Залуучуудын Эвлэл байгуулагдсан нь шинэ цагийн төрийн бум байгууллагууд олноор үүсэн байгуулагдах анхны гарсаа байлаа.

1924 онд хуралдсан Улсын I их хурлаар баталсан анхдугаар Үндсэн хуульд хөдөлмөрчдийн олон нийтийн байгууллагад эвлэлдэн нэгдэх эрхийг монголын ард түмний түүхэнд анх удаа тунхаглаж, эрх зүйн үндсийг бүрдүүлжээ. Тус Үндсэн хуульд: "Жинхэнэ олон ардын аливаа эвлэл хоршоо зэргийг байгуулах, эрх чөлөөг хүндэтгэх, эл явдалд тус улсаас элдэв тусламж үзүүлбэл зохино"<sup>1</sup> гэж заажээ. Чингэнээр монголын ард түмэн залуучууд, үйлдвэрчний эвлэл, эмэгтэйчүүд, пионерийн төрийн бус байгууллагад эвлэлдэн нэгджээ.

1920-иод оны нам, эвлэлийн хооронд гарч байсан зөрөлдөөнийг МХЗЭ залуучуудын улс төрийн нам болохыг оролдож байсан гэхээс илүү төрийн бус байгууллагын хувьд жам гольдролоороо бие дааж ажиллахыг эрмэлзэн тэмүүлж байсан гэж хэлж болохоор байна. Эл зөрөлдөөн намжсаны дараагаар монголын төрийн бус байгууллагууд нам, ард түмний холбоог бэхжүүлэх нэгэн шижим гэж өөрсдийгээ ухамсарлан, эрх баригч намын шийдвэрийг хэрэгжүүлэгч хэрэгсэл болон хувирчээ.

Социализмын үед төрийн бус байгууллагуудыг "олон нийтийн байгууллага" хэмээн томъёолж байв. Олон нийтийн байгууллагууд нийгмийн улс төрийн системд чухал байр суурь эзэлж байсан юм. Нэгэнт уг системийн бүрэлдэхүүн хэсэг учраас бусад бүрэлдэхүүн хэсгүүдтэй няйт нэгдэлтэй оршиж, нийтлэг үндэслэлүүдээр тодорхойлогдож байлаа.

БНМАУ-ын нийгмийн улс төрийн системийн бүрэлдэхүүн хэсгүүд няйт нэгдэлтэйн зэрэгцээгээр нөгөө талаар уг системд тодорхой байр суурь эзлэн, бие даан оршиж, тодорхой үүрэг роль гүйцэтгэж байсан юм.

БНМАУ-ын нийгмийн улс төрийн системд хөдөлмөрчдийн олон нийтийн байгууллагын эзлэх байр суурь нь: нэгдүүгээрт, нийгмийн улс төрийн системийн бүтэц, бүрэлдэхүүнд, хоёрдугаарт, социалист аж ахуйн систем, түүний хөгжилд, гуравдугаарт, ард түмний бүрэн эрх, ард түмний улс төрийн засаглалыг хангахад, дөрөвдүүгээрт, нийгмийн удирдлагыг хэрэгжүүлэхэд, тавдугаарт, социалист нийгмийн гишүүдийг төлөвшүүлэн хүмүүжүүлэхэд, зургадугаарт, бие

<sup>1</sup> Монгол Улсын Үндсэн хуулиуд, тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтүүд /1924-1992/ УБ., 1998. 5 дахь тал

хүнийг бүх талаар хөгжүүлж, иргэдийн эрх, эрх чөлөөг хангахад гүйцэтгэж буй үүрэг ролиор тодорхойлогдож байв.

БНМАУ дахь олон нийтийн байгууллагыг зарим эрдэмтэн судлаачид тэдгээрийн гүйцэтгэж байгаа роль, эрх үүрэг, үйл ажиллагааны чиглэл, хүрээ, онцлог бүтэц бүрэлдэхүүн зэргийг үндэслэн дараах үндсэн ангиллыг хийж байв. Үүнд:

1. Үйлдвэрчний байгууллага /МҮЭ, салбарын үйлдвэрчний эвлэлийн байнгын зөвлөл/
2. Залуучуудын байгууллага /МХЗЭ, Монголын Пионерийн Байгууллага, Монголын Оюутны Холбоо/
3. Хоршооллын байгууллага /ХААН, Нэгдэл дундын хоршоолол, ХААН-ийн холбоо/
4. Уран бүтээлчдийн эвлэл, холбоо /Монголын архитекторчид, сэтгүүлчид, хөгжмийн зохиолчид, урчуудын эвлэл, холбоо зэрэг/
5. Сайн дурын нийгэмлэг. Үүнд: Улс төр, шинжлэх ухаан-суртал нэвтрүүлгийн нийгэмлэг. /Монголын эрдэм дэлгэрүүлэх нийгэмлэг/, Соёл боловсролын нийгэмлэг, холбоо /Монголын урлагийн ажилтны холбоо, орос хэлний багш нарын холбоо, марк цуглуулагчдын холбоо г.м/, Шинжлэх ухааны нийгэмлэг. /Шинжлэх ухааны ажилтны холбоо, түүхч, хуульчдын холбоо, монголын эмч, эм найруулагчдын нийгэмлэг г.м/, Шинжлэх ухаан, тенхикийн нийгэмлэг /Шинийг санаачлагчдын нийгэмлэг /байгаль орчныг хамгаалах нийгэмлэг, анчдын нийгэмлэг/, Биеийн тамирын нийгэмлэг холбоод /Хоршоолол нийгэмлэг, үндэсний бөхийн холбоо зэрэг/, Батлан хамгаалах нийтлэг /Улсыг батлан хамгаалахад туслах нийгэмлэг/, Нийгмийн тусламж дэмжлэг үзүүлэх нийгэмлэг /Монголын улаан загалмай нийгэмлэг, Монголын хараагүй, хэлгүй, дүлий иргэдийн нийгэмлэг/, Энхтайван, найрамдлын нийгэмлэг /Монголын энх тайван, найрамдлын байгууллагуудын холбоо, түүнд нэгддэг найрамдлын нийгэмлэгүүд, энх тайвны хороо, улс түмний эрх чөлөө тогтол, дэвшилт тэмцлийг дэмжих хороо зэрэг/ гэж хуваана.

Олон нийтийн сайн дурын байгууллагуудыг улс төр, аж ахуй, соёлын ямар салбарт байгуулагдан ажиллаж байгааг нь харгалзан:

1. Орон сууц-нийтийн аж ахуй үйлчилгээний салбар дахь сайн дурын байгууллага /байрын зөвлөл, ОСГ-ны хороо г.м/
2. Аж үйлдвэрийн салбар дахь сайн дурын байгууллага /чанарын комисс, уралдааны комисс, тэргүүн туршлагын комисс г.м/
3. Эрүүлийг хамгаалахын салбар дахь сайн дурын байгууллага /эмнэлгийн байгууллагууд дахь эмч, сувилагчдын зөвлөл г.м/
4. Ардын боловсролын салбар дахь сайн дурын байгууллага /сургуулийн эцэг эхийн хороо, зөвлөл, багш, хүмүүжүүлэгчдийн зөвлөл, клубын зөвлөл г.м/
5. Соёл гэгээрлийн салбар дахь сайн дурын байгууллага /соёлын ордон, клуб, номын сангийн зөвлөл г.м/
6. Нийгмийн хэв журам хамгаалах салбар дахь сайн дурын байгууллага /нийгмийн хэв журам хамгаалах ардын нөхөрлөл, олон нийтийн шүүх, гэмт хэрэг, нийгмийн хэв журмын зөрчлөөс сэргийлэх хөдөлмөрийн хамт зөвлөл г.м/ гэх зэргээр хувааж үзэж байлаа.

1980-аад оны дунд үе гэхэд социалист байгуулалтанд хөдөлмөрчдийн олон нийтийн байгууллага нь нэгдүгээрт: социалист байгуулалтад хөдөлмөрчин олон түүний идэвхийт өрнүүлэн, ажилчин анги, хоршооллосон ард, хөдөлмөрийн сэхээтнийг төр, нийгмийн үйл хэргийг удирдахад оролцуулах, хоёрдугаарт: МАХН-ыг олон түмэнтэй холбон, тэднийг намыг тойруулан нягтуулах, гуравдугаарт: тус орны насанд хүрсэн бараг бүх хүнийг хамарч

байгаа болохоор олон түмний нийгмийн санаачлагыг өрнүүлэх, өөрөө удирдах ёсны үүсгэлийг хөгжүүлэх өргөн бололцоог бүрэлдүүлэх чухал хэлбэр мөн гэж үзэж байв.

Гэвч МАХН-аас олон нийтийн байгууллагын ажилд тэдгээрийн удирдах боловсон хүчнийг чиглэл өгч сонгох, томилох, дотоод хэрэгт нь шууд хутгалдан оролцох зэргээр бие даасан байдлыг нь алдагдуулж байлаа. Олон нийтийн байгууллагуудын ажилд хэлбэрдэх, загвардах явдал ч газар авсан байв. МҮЭ зэрэг байгууллага төрийн зарим үүргийг шилжүүлснээр ихээхэн төржсөн агуулгатай болж, олон нийтийн шинжийг нь улам бүр алдагдуулж байв. Харин 1986 оноос хойш тус улсын олон нийтийн байгууллагын тогтолцоонд ардчилсан шинэ уур амьсгал аажим аажмаар нэвтэрч эхэлсэн юм. Энэ үед болсон МҮЭ, МХЗЭ-ийн болон бусад олон нийтийн байгууллагуудын их хурлууд болж, тус бүрдээ нийгмийн амьдралын бүх хүрээнд гүйцэтгэх тодорхой зорилт дэвшүүлжээ. Тухайлбал, эдгээр их хурлууд олон нийтийн байгууллага бүрийн бие даасан үйл ажиллагааг хангах, ажлын арга барилыг өөрчлөн шинэчлэх талаар шинэ шинэ санаа дэвшүүлсэн юм. Тодруулж хэлбэл, нийгмийн амьдралд МҮЭ, МХЗЭ, эмэгтэйчүүд, ахмадын болон олон нийтийн бусад байгууллагаас үзүүлэх үр нөлөөг дээшлүүлэх, олон нийтийн байгууллагуудын бие даасан байдал, өөрөө санаачлагч шинжийг хангах, үүний хамт эдгээр байгууллагаас гишүүдийнхээ эрх ашгийг хамгаалж, тэдний хүсэл саналд нийцсэн ажил зохион байгуулахад өөрчлөлт шинэчлэлийн мөн чанар оршиж байв. Энэ үеэс МАХН, олон нийтийн байгууллагуудын харилцааны агуулга, хэлбэр өөрчлөгдөв.

1990 оны эхээс МҮЭ, МХЗЭ зэрэг олон нийтийн байгууллагууд бүрэн бие дааж үйл ажиллагаагаа явуулах болов. МАХН-ын Онц их хурал (1990): "МАХН-наас үйлдвэрчин, залуучууд, эмэгтэйчүүд, оюутны зэрэг байгууллагын хувьд тэдний дотоод хэрэгт оролцохгүй, тэгш эрхийн зарчим дээр харилцаж байх болно"<sup>2</sup> хэмээн онцлон тэмдэглэжээ.

1980-аад оны сүүлчээс Монгол дахь төрийн бус байгууллагын хөгжил нь нэгдүгээрт: уламжлалт слон нийтийн байгууллагуудын үйл ажиллагааны агуулга, хэлбэр шинэчлэгдэн өөрчлөгдөх чиглэлээр, хоёрдугаарт: олон нийтийн шинэ ардчилсан хөдөлгөөн, нэгдэл, байгууллага үүсэн бий болох замаар өрнөжээ. Үүнээс эл зүйлд уламжлалт олон нийтийн байгууллагын хувьсал хөгжлийг товч өгүүлье.

Монголын залуучуудын холбоо /цаашид МЗХ.М.Б/ 1991 оны 1 сарын 18-нд хуралдсан МХЗЭ-ийн ХХ их хурлын шийдвэрийн дагуу МХЗЭ-ийн бааз суурин дээр түүний албан ёсны залгамжлагч гэдгээ зарлан байгуулгадаж, холбооны баримтлал, үйл ажиллагааны ойрын чиглэл дүрмийг хэлэлцэж баталсан байна.

1993 онд хуралдсан МЗХ-ны II Ерөнхий чуулганаар төрөөс залуучуудын талаар баримтлах шинэ бодлогын үндсийг томъёолж, энэхүү бодлогыг боловсруулан хэрэгжүүлэхэд Монголын Залуучуудын Холбооны үүрэг, байр суурийг тодорхойлж, Монгол орны залуу үеийнхний талаар баримтлах "Шинэ үе-Шинэ бодлого"-ыг дэвшүүлэн, нийгэмд зүй зохистой ёс зүйн хэм хэмжээ бүрдүүлэн залуучуудад эрхэм дээд эрмэлзэл бий болгохын тулд "Монгол залуу хүний эрмэлзэх 9 зүйл"-ийг тунхаглажээ.

1997 онд хуралдсан МЗХ-ны III Ерөнхий чуулган Монголын Залуучуудын өмнө "Шинэ үе-Шинэ бодлого"-ын хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилтыг тавьж, шинэ зуунд улс орноо авч явах залуу үеийнхний төлөвшүүлэх, шинэ нийгмийн бүтээн байгуулах үйлсэд залуучуудын оролцоог идэвхжүүлэх, "Хичээх үзэл"-ийг нийт залуучуудын эрхэм үзэл болгох зорилтыг дэвшүүлэн тавьсан юм.

МЗХ-ны үндсэн зорилго нь залуучууд эх орон, ард түмнийхээ төлөө бүтээлчээр ажиллаж амьдрах, шинийг санаачлах сэтгэлгээг төлөвшүүлж, оюуны

<sup>2</sup> МАХН-ын онц их хурал. УБ., 1990

болон бие бялдар, ёс зүйн зөв хүмүүжил олоход нь дэмжлэг үзүүлэх, ард түмний түүх соёл, ёс заншлын уламжлалыг өвлүүлэх, залуучуудын хөгжлийг урамшуулан дэмжих, тэдний дэлхий ертөнцөд хөл тавихад нь туслах явдал юм. МЗХ нь шинэ үеийнхний талаар баримтлах төрийн бодлогыг боловсруулахад идэвхитэй оролцохын хөдөлмерийн харилцааны эрх зүйн зохицуулалтыг буй болгох, хэрэгжилтийг нь хянах, идэвхтэн, сонгуультныхаа мэргэжил боловсролыг дээшлүүлэх, хоёр болон гурван талын түншлэлийн харилцааг төлөвшүүлэх, гадаад харилцаагаа үзэл сурталжсан явцуу хүрээнээс гаргаж, орон зайг тэлэх бодлого явуулж, хэрэгжүүлж байна.

Сүүлийн жилүүдэд үйлдвэрчний эвлэлийн хөдөлгөөнд бий болсон нэг үндсэн өөрчлөлт нь Засгийн газар, ажил олгогч, улс төрийн нам, эвсэл, холбоодоос хараат бус бие даасан үйлдвэрчний эвлэлийн үндэс суурийг бэхжүүлж ирсэн явдал юм. Эдүгээ МҮЭ аль ч шатандаа бие даасан үйл ажиллагаа явуулж, бодлого шийдвэрээ тодорхойлж, ажиллах чадвар нь байнга тогтвортой болж байна. Үүний үрээр МҮЭ-үүд өөрийн байр сууриа нийгэмд хүлээн зөвшөөрүүлж чаджээ. Тухайлбал, МҮЭ-ийн бүх байгууллагууд "Үйлдвэрчний эвлэлийн эрхийн тухай" Монгол улсын хуулийн дагуу Хууль зүйн яаманд бүртгэлтэй хуулийн этгээд байж, хөдөлмөр нийгмийн хамгааллын гурван талт бүтцэд оролцогч талын үүргээ зохих ёсоор гүйцэтгэсээр ирснийг олон нийт хүлээн зөвшөөрч байна. Үүнийг 2000 онд МҮЭ-үүдийн холбооны эрдэм шинжилгээ-судалгааны төвөөс явуулсан судалгааны дүн нотолж байна. Тус төвөөс 1100 хүний дунд социологийн судалгаа явуулж, "Та Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн талаар ямар сэтгэгдэлтэй байдаг вэ?" гэсэн санал асуулга оролцогсдын 40 гаруй хувь нь "Оюуны болон биеийн хүчинээ үнэлүүлж ажиллаж буй хүмүүсийн эрх ашгийг хамгаалдаг хөдөлмөрчдийн байгууллага"<sup>3</sup> гэж хариулжээ.

МҮЭ цаг үеийн шаардлагад нийцүүлэн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны зарим арга барилгаа өөрчлөн шинэчилж, үндэсний төвөө нэгдсэн холбооны, нутаг дэвсгэр болон салбарын үйлдвэрчний эвлэлүүдийг холбооны зарчимд шилжүүлснээр үйлдвэрчний эвлэлийг удирдах эрхийг гишүүдэд бодитойгоор өгсөн төдийгүй, шат шатны байгууллагын бие даасан байдлыг хангах, ажлын янз бүрийн арга хэлбэрийг сонгон ажиллах бололцоог бүрдүүлэхэд чухал алхам хийсэн байна. Ийнхүү өөрчлөлт шинэчлэлийн үр дүнд МҮЭ-үүдэд шинэ зуунд төлөвшин хөгжих ерөнхий чин хандлага зөрэгээр бүрдсэн гэж үзэж болохоор байна.

МҮЭ-үүдийн Холбооны ойрын үед баримтлах бодлого, хэрэгжүүлэх үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл нь:

- Эдийн засгийн хүрээнд тогтвортой бөгөөд байгаль орчин, нийгэмд нийлэмжтэй, төрийн зохицуулалт, оролцоо бүхий хөгжлийн бодлогыг тууштай дэмжих,

- Эдийн засгийн өсөлт болон хөдөлмөр эрхлэлтийн харилцан шүтэлцээг хангасан төрийн бодлого боловсруулахад нөлөөлж, ажилгүйдлийг бууруулах,

- Хөдөлмөрийн харилцааг төлөвшүүлэн хууль эрх зүйн үндсийг нь боловсронгуй болгох,

- Цалин хөлс, орлого, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлж, хүмүүсийн ажиллаж амьдрах орчин' нөхцлийг сайжруулах,

- Улс төрийн ардчиллыг төлөвшүүлж, иргэний нийгэм байгуулахад хувь нэмэр оруулах,

- Хөдөлмөрчдийн соёл, боловсролын түвшинг дээшлүүлэх,

- Нийгмийн түншлэлийн механизмыг төгөлдөржүүлж, эзэд хөдөлмөрчдийн хамтын ажиллагааг өргөжүүлэх,

<sup>3</sup> Шинэ зуун-хөдөлмөрийн хүн-үйлдвэрчний эвлэлийн бодлого, зорилт. УБ., 2000. 23 дахь тал

- Үйлдвэрчний эвлэлийн хөдөлгөөний хөгжлийг хангаж бэхжүүлэх явдал болж байна.

Уламжлалт олон нийтийн байгууллагын дотор эмэгтэйчүүдийн байгууллага чухал байр эзэлж байв. Эмэгтэйчүүдийн байгууллага эмэгтэйчүүдийн улс төр, хөдөлмөрийн идэвхийг дээшлүүлэх, тэдний боловсрол мэдлэгийн төвшинг өндөржүүлэх, үр хүүхдээ хүмүүжүүлэх, ахуйн соёлыг нэвтрүүлэн хэвшүүлэх чиглэлээр ажиллаж байлаа. 1990-ээд оноос эмэгтэйчүүдийн байгууллагын үйл ажиллагааны цар хүрээ, хэлбэр, арга барил өөрчлөгдж, үзэл бодол, мэргэжлийн чиглэлээр эмэгтэйчүүдийн олон төрлийн байгууллага байгуулагдаж, Монголын эмэгтэйчүүдийн холбоонд нэгдэн ажиллах болов.

Түүнчлэн социализмын үед байгуулагдсан Монголын хүүхдийн байгууллага, Найрамдлын нийгэмлэгүүд, Эрдэм дэлгэрүүлэх нийгэмлэг, Монголын зохиолчдын эвлэл, УБ ХТН, Монголын оюутны холбоо, Монголын улаан загалмай нийгэмлэг, Сэтгүүлчдийн холбоо' Урчуудын эвлэлийн хороо, Хөгжлийн зохиолчдын холбоо, Урлагийн ажилтны холбоо зэрэг олон нийтийн байгууллагууд үйл ажиллагаандaa уламжлал, шинэчлэлийг хослуулан, шинэ сэтгэлгээ, шинэ арга барилаар ажиллаж байна. Олон улсын Улаан загалмайн байгууллагуудын шугамаар хүмүүнлэгийн тусламж өсч байгаагийн үрээр Монголын улаан загалмай нийгэмлэгийн үйл ажиллагааны цар хүрээ илт өсч байна. Зарим байгууллагууд задарч, арай өөр өнгө аяс, чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байгаа боловч, дээр дурдсан олон нийтийн байгууллагууд өмнө үеэ хууль ёсоор залгамжилж, шинэ нөхцөлд дасан зохицож, шинийг эрэлхийлэн ажиллаж байна.

Уламжлалт олон нийтийн байгууллагын үйл ажиллагаанд: **нэгдүгээрт**, үзэл баримтлалын хувьд шинэчлэгдэж, ардчилал, зах зээлийн нөхцөлд дасан зохицож ажиллаж буй, **хоёрдугаарт**, зохион байгуулалтын хувьд нүсэр бүтэц, аппаратгүй цомхон чадварлаг ажиллах арга зүйд суралцаж байгаа, **гуравдугаарт**, өөрийгөө санхүүжүүлэх зарчим дээр ажиллах болсон, **дөрөөдүгээрт**, гадаад орнуудын ялангуяа өрнө, дорнын өндөр хөгжилтэй орнуудын төрийн бус байгууллага, сантай харилцах өргөн боломж нээгдсэн зэрэг нийтлэг шинжүүд ажиглагдаж байна. Ийнхүү уламжлалт төрийн бус байгууллагууд шинэ нөхцөлд дасаж зохицох, үлдэж хоцрох зарчим баримтлан ажилласнаас ардчилсан үндсэн дээр өөрчлөгддөг, төрийн бус байгууллагын тогтолцоонд зохих байр сууриа эзэлж чаджээ. Эдүгээ манай оронд 700 хүн тутамд нэг ТББ ногдож байгаа нь өөрчлөлт шинэчлэлийн жилүүдэд Монголын нийгмийн янз бүрийн бүлэг, давхрааны нийгэм-улс төрийн идэвхийн өндөр үзүүлэлт бөлгөө.

**Absract:**

In the immediate aftermath of the 1921 national democratic revolution the first non-governmental organizations were formed in Mongolia, the most prominent of which were the Mongolian Revolutionary Youth League and the Mongolian Trade Unions' Federation. In the late 1980s and early 1990s, those traditional NGOs were transformed in accordance with the demands of the reforms undertaken in the country.

These transformations of the traditional NGOs include the following aspects, namely: first, transformation in the sphere of ideology to meet the requirements of a democratic society and free-market economy; second, departing from an overbureaucratized structure to learning to operate as capable organizations with limited staff; third, acquiring the capacity to operate in a self-sufficient matter of funding; and fourth, establishing wide range of contacts and collaboration with the similar NGOs abroad.